


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

“Оюу толгой” ХХК-ийн 2020 оны III улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.



2020 оны III улирлын байдлаар
20,805,511
Хүн/цаг

Гүйцэтгэл
0.17

2020 оны III улирлын байдлаар 200,000 хүн/цаг тутамд ногдох гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 0.17 байлаа.



Ноцтой эрсдэлийн удирдлага

140,276
Магадлагаа

Амь хамгаалах зорилготой “Ноцтой эрсдэлийн удирдлага” хөтөлбөрийн хүрээнд 140,276 магадлагаа хийлээ.

МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

94.7%

Нийт ажиллах хүчний 94.7 хувийг монгол иргэд бүрдүүлж байна. Үүнээс 49 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.



БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)



Нийт 318,927 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш
2600 оюутан,

ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
2013 оноос хойш ахлах ангийн **1095** сурагч,

“ГОВИЙН ОЮУ” САНГИЙН ТЭТГЭЛЭГ
2015 оноос хойш Өмнөговийн **320** оюутан тус тус хамрагджээ.

ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2020/03 улирал, сая ам.доллар)



2020 оны III улиралд үйл ажиллагааны худалдан авалтын баг 703 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 468 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компаниуд худалдан авалтынхаа 73 хувийг зарцуулав. 2010-2020 оны III улирлын хооронд үндэсний худалдан авалтад 3.45 тэрбум ам.доллар зарцуулсан.


УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)



УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)



УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2020/03 улирал)



87.5%

2020 оны эхний гурван улиралд зорилтоо давуулан биелүүлж ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 87.5 хувьд хүргэв.




МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

"Оюу толгой" ХХК-ийн 2020 оны III улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2020/03 улирал, сая ам.доллар)



2010-2020 онд өсөн нэмэгдсэн дүнгээр

2.8

ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.


2010 - 2020 оны III улирлын хооронд татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 2.8 тэрбум ам.долларыг төлсөн. 2020 оны эхний гурван улиралд татвар, хураамж бусад төлбөрт 201 сая ам.доллар төлжээ.

* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2010 - 2020/03 улирал, тэрбум ам.доллар)


2010-2020 оны III улирлын хооронд үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 11.3 тэрбум ам.доллар давлаа.



11.3 ТЭРБУМ

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД


(сая ам.доллар)



2020 оны III улирлын байдлаар тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 5.9 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2020/03 улирал, сая ам.доллар)



2020 оны III улирлын байдлаар Өмнөговь аймагт бүртгэлтэй 78 ханган нийлүүлэгч манайд бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010-2020 оны гуравдугаар улирлын байдлаар Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 635 сая ам.доллар зарцуулжээ.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ

(мян.тонн)



2020 оны III улиралд 36,286 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 140,000 – 170,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх жилийн төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(мян.унц)



2020 оны III улиралд 36,743 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. 155,000-180,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)



2020 оны III улирлын байдлаар гүний уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл 15,672 метр, харин налуу амны малталтын ажил 2,988 метрийн ахицтай байлаа.